



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ

Миша Гофорт, Т. Чимэгсанаа
2019 ОНЫ 6-Р САРЫН 18-НЫ ӨДӨР

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО

Бодлого, хөтөлбөр яагаад “жендэрийн мэдрэмжтэй” байх хэрэгтэй вэ?

- Эмэгтэй, эрэгтэй хүмүүс ялгаатай хэрэгцээ шаардлага, чухалчлах зүйлстэй байдаг.
- Аливаа асуудал тэдэнд өөр өөрөөр тусдаг.
- Тэд өөр өөр бэрхшээлтэй тулгардаг төдийгүй ялгаатай давуу талуудтай.
- Тэд ялгаатай төрлийн дэмлэг туслалцааны үр шимийг хүртдэг.

Аливаа бодлого нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүд, нийгмийн бусад бүлгүүдэд өөр өөр үр нөлөөтэй байдаг.

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО

Хүмүүсийн ялгааг үл тоож, нэг цул бүлэг хэмээн ханддаг.



Жендэрийн мэдрэмжгүй бодлого, хөтөлбөр

Хүмүүсийн ялгааг мэдэрч анхаардаг, цаашлаад тэдний хэрэгцээг нь чухалчилдаг.



Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөр

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Жендэрийн практик буюу бодит хэрэгцээ

- Материаллаг хүчин зүйлс, тухайн үеийн ашиг сонирхол, хэрэгцээтэй холбоотой.
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүс өөрсдөө тодорхойлж илэрхийлэхэд хялбар.
- Богино хугацааны арга хэмжээгээр хангах боломжтой.


Жендэрийн стратеги хэрэгцээ

- Эрх мэдэл, хяналтын асуудалтай холбоотой.
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүс өөрөө илрүүлэн гаргах, илэрхийлэхэд хэцүү.
- Уг хэрэгцээг илрүүлж ойлгоход нарийвчилсан дүн шинжилгээ, судалгаа хийх шаардлагатай.
- Цаад шалтгааныг нь урт хугацааны арга хэмжээгээр шийдвэрлэдэг.

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ




ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ



Жендэрийн дүн шинжилгээ хийх зөвлөмж (Жулиет Хант)

1. Хүйсээр ангилсан тоо мэдээ цуглуулах
2. Тодорхой чиглэлд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцоо, үүрэг роль ямар байна вэ?
3. Тодорхой чиглэлд хуваарилсан нөөцөөс хэн хамгийн их үр өгөөж хүртэж байна вэ?
4. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдэд ямар ялгаатай хэрэгцээ байна вэ? Эдгээр бүлэгт ямар бэрхшээл тулгардаг вэ? Тэдэнд ямар давуу тал байна вэ?
5. Жендэрийн тэгш бус байдлыг арилгах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх ямар боломж байна вэ?
6. Эрх тэгш байдлыг тогтооход ямар саад бэрхшээл тулгарч болзошгүй вэ?
7. Бодлого хөтөлбөр нь төлөвлөлт, хэрэгжилт дэх тэдгээр саад бэрхшээлийг хэрхэн давж гарч болох вэ?
8. Манай хамтрагч байгууллагуудын жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх чадавх нь ямар байна вэ? Чадавхыг нь хэрхэн сайжруулж болох вэ?

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ ДАСГАЛ АЖИЛ



Дараах асуултуудын хүрээнд оюун бодлоо уралдуулна. Үүнд:

- Тухайн асуудлын жендэрийн хэмжээс нь юу байж болох вэ?
- Уг асуудлыг ойлгохын тулд ямар асуултуудад хариулах хэрэгтэй вэ?
- Хэрэгтэй мэдээллээ хэрхэн цуглуулах вэ?
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай туршлагад хэрхэн мэдрэмжтэй хандсан хэвээр байх вэ?

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨЛӨВЛӨЛТ

Төлөвлөлтийн шатанд яагаад “жендэр”-ийг тусгах шаардлагатай вэ?

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмэр оруулуулахын тулд төслийн зорилго, зорилт, үйл ажиллагааг уялдуулах
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг анхаарч үзэх
- Бодлого, хөтөлбөрийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст үзүүлэх үр нөлөөг урьдаас тооцоолж, саад бэрхшээлийг шийдвэрлэхүйц байдлаар төслийг нь боловсруулах

Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөр нь “жендэрийн тооны харьцаа” болон хүйсээр ангилсан тоо мэдээгээр хязгаарлагддаггүй.


ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨЛӨВЛӨЛТ




Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт хийх зөвлөмж (Харвардын загвар)

1. Бодлого, хөтөлбөрийн зорилго нь жендэрийн ялгааг анхаарч үздэг, эсвэл жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой юу?
2. Өөр өөрийн гэсэн онцлогтой нийгмийн бүлгийнх нь хувьд эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн хэрэгцээг зорилтуудад тусгасан уу?
3. Оролцогч талуудын эмэгтэй, эрэгтэй төлөөллүүд зорилт боловсруулахад оролцсон уу?
4. Үйл ажиллагаа нь зорилтдоо хүрч, зорилтот үр дүнг бий болгоход дэмжлэг үзүүлдэг үү?
5. Хэрэгжилтийн жендэрийн мэдрэмжтэй стратеги байгаа юу?
6. Төслөөс эмэгтэй, эрэгтэй хүмүүст ямар сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй вэ? (Нэмэлт судалгаа, зөвлөгөөн хийх шаардлагатай байж болно – Богино болон урт хугацааг анхаарч үзээрэй.)
7. Бодлого хөтөлбөрийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст үзүүлж буй үр нөлөөг хянах боломжтой юу? Өөрчлөгдөж буй хэрэгцээнд дасан зохицохуйц хангалттай уян хатан үү?

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨЛӨВЛӨЛТ



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨЛӨВЛӨЛТ ДАСГАЛ АЖИЛ



Дараах зүйлсийг тодорхойлно уу.

- Нэг үндсэн зорилго
- 2 зорилт
- 2 үйл ажиллагаа
- Хэрэгжилтийн явцад жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2 стратеги
- *Та хэрхэн эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш үр дүн, үр нөлөө авчрах вэ?*

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

Яагаад хяналт шинжилгээ “жендэрийн мэдрэмжтэй” байх хэрэгтэй вэ?

- Аливаа бодлого, хөтөлбөрийн эмэгтэй, эмэгтэй хүмүүст бий болгох ялгаатай үр нөлөөг ойлгож, үнэлэх
- Тэгш бус байдал, сөрөг нөлөөллийг өөгшүүлэхээс зайлсхийх
- Бодлого хөтөлбөрийн *бодит* үр нөлөөг ойлгох
- Сургамж, түгээн дэлгэрүүлэх, дахин боловсруулах боломжийг үнэлэх

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

Жендэрийн мэдрэмжтэй хяналт-шинжилгээний шаардлага:

- Шийдвэр гаргах түвшинд жендэрийн асуудал, тэгш бус байдлыг авч үзэн, үнэлэх
- Шалгуур үзүүлэлтүүд нь жендэрийн мэдрэмжтэй, жендэрийн мэдрэмжтэй гарц, үр нөлөөг хэмждэг.
- Жендэрийн мэдрэмжтэй эцсийн тайлан. Үүнд үр дүн, үр нөлөөний үнэлгээ болон сайжруулах санал зөвлөмж багтана.

Жендэрээр ангилсан мэдээ мэдээллийг өөртөө агуулдаг ч зөвхөн үүгээр хязгаарлагддаггүй.

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



Жендэрийн мэдрэмжтэй хяналт шинжилгээний төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

1. Жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлт гаргах
 - Шалгуур үзүүлэлт бол ахицыг хэмжих үзүүлэлт бөгөөд тоон болон чанарын өөрчлөлтийг хэмждэг.
 - Шалгуур үзүүлэлт нь бодлого, хөтөлбөрийн зорилт өөд гаргаж буй ахицыг хэмждэг бөгөөд зорилтот гарц, үр нөлөөтэй (богино хугацааны, дунд хугацааны, эцсийн үр нөлөө) уялдаатай байдаг.
2. Нас, хүйсээр ангилсан тоон болон чанарын мэдээлэл цуглуулах
3. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг мэдээллийн эх сурвалжаа болгох, мэдээлэл цуглуулахдаа жендэрийн мэдрэмжтэй аргачлал ашиглах
4. Шалгуур үзүүлэлтийн биелэлтээс хамаарч бодлого, хөтөлбөрийг өөрчлөн засварлаж, дахин төлөвлөх боломжтой байлгах

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ДАСГАЛ АЖИЛ

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг судалж, дараах зүйлсийг хэлэлцэнэ.
Үүнд:

- А) Ямар чанарын болон тоон мэдээлэл шаардлагатай байна вэ?
- В) Энэ мэдээллийг бид хэрхэн цуглуулах вэ? Хэнтэй зөвлөлдөх вэ?
Ямар эх сурвалж, аргыг ашиглаж болох вэ?

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ДАСГАЛ АЖИЛ

Үр дүнд нь дараах зүйлсийг тодорхойлно уу.

- Жендэрийн мэдрэмжтэй 2шалгуур үзүүлэлт
- Шалгуур үзүүлэлтээ хянахын тулд мэдээлэл цуглуулах 2 аргачлал
- Өөрчлөгдөж буй хэрэгцээнд нийцүүлэн бодлого, хөтөлбөрөө өөрчлөх стратеги
- *Хэрэв нэг шалгуур үзүүлэлт хангалтгүй биелэлттэй байвал танай баг хэрхэн зохицох вэ?*

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨТӨЛБӨРИЙН КЕЙС

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖГҮЙ ТӨЛӨВЛӨЛТ

ЗОРИЛГО: Монгол Улсын зорилтот гурван аймаг (Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай) дахь хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай ЖДҮ-үүдийн зээл авах боломжийг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх

ЗОРИЛТУУД:

- ЖДҮ-ийн зээлийн шалгуурыг хангах чадавхыг бэхжүүлэх
- Арилжааны банкны ЖДҮ-д зээл олгох үйл явцыг хөнгөвчлөх

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Зорилтот аймаг, орон нутаг дахь ЖДҮ-үүдийн зээл авах хэрэгцээг тодорхойлох
- Зээлжих чадварыг сайжруулснаар зээл авах үйл явцыг нь хөнгөвчлөх
- Зан байдлыг нь өөрчлөх, санхүүгийн боловсрол олгох сургалтаар дамжуулан ЖДҮ-ийн санхүүгийн оролцоог хангах

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨТӨЛБӨРИЙН KEYC

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖГҮЙ ТӨЛӨВЛӨЛТ

ЗОРИЛТ №1: ЖДҮ-ийн зээлийн шалгуурыг хангах чадавхыг бэхжүүлэх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- ЖДҮ-ийн зээл авсан тоо
- ЖДҮ-ийн зээл хүсэж гаргасан өргөдлийн тоо,
- Техникийн туслалцаа авсан, сургалтад хамрагдсан ЖДҮ-ийн тоо
- Менежментийн практик, арга технологи нь сайжирсан ЖДҮ-ийн тоо

ЗОРИЛТ №2: Арилжааны банкны ЖДҮ-д зээл олгох үйл явцыг хөнгөвчлөх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Хөнгөлөлттэй зээлийн дүн

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨТӨЛБӨРИЙН KEYC

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖГҮЙ ҮР ДҮН

ГАРЦ



Хөнгөлөлттэй зээл
олгосон тоо:

700

ГАРЦ



Зөвлөн туслах
үйлчилгээ авсан
ЖДҮ-ийн тоо:

500

ҮР НӨЛӨӨ



Чадавхжсан ЖДҮ-
ийн тоо:

500



Хөнгөлөлттэй
зээлийн нийт дүн:

**75 тэрбум
төгрөг**

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨТӨЛБӨРИЙН KEYC

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ЗОРИЛТ №1: ЖДҮ-ийн зээлийн шалгуурыг хангах чадавхыг бэхжүүлэх
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- *ЖДҮ эрхлэгч эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн зээл авсан тоо*
- *ЖДҮ-ийн зээл хүсэж гаргасан өргөдлийн тоо, **жендэрээр***
- *Техникийн туслалцаа авч, сургалтад хамрагдсан ЖДҮ, **жендэрээр***
- *Менежментийн практик, арга технологио сайжруулсан ЖДҮ-ийн тоо, **жендэрээр***

ЗОРИЛТ №2: Арилжааны банкны ЖДҮ-д зээл олгох үйл явцыг хөнгөвчлөх
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- *Эмэгтэй болон эрэгтэй эзэнтэй ЖДҮ-д олгосон хөнгөлөлттэй зээлийн дүн*

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨТӨЛБӨРИЙН KEYC

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ГАРЦ



Хөнгөлөлттэй зээл
олгосон тоо:

700

45% эмэгтэй
55% эрэгтэй

ГАРЦ



Зөвлөн туслах
үйлчилгээ авсан ЖДҮ
эрхлэгчийн тоо:

500

60% эмэгтэй
40% эрэгтэй

ҮР НӨЛӨӨ



Чадавхжсан ЖДҮ-
ийн тоо:

500

60% эмэгтэй
40% эрэгтэй



Хөнгөлөлттэй
зээлийн нийт дүн:

75 тэрбум төгрөг

33% эмэгтэй
66% эрэгтэй

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨТӨЛБӨРИЙН KEYC

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ҮР ДҮН

ҮР ДҮН

- Зээлийн хүсэлт гаргасан ихэнх эрэгтэй ЖДҮ эрхлэгч амжилттай зээл авсан бол эмэгтэй ЖДҮ эрхлэгчийн хүсэлтэд татгалзсан хариу өгчээ.
- Эрэгтэйчүүд 40 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зээл олныг авсан байхад ихэнх эмэгтэйчүүд 20 сая төгрөгнөөс доош дүнтэй зээл авчээ.
- Ихэнх тохиолдолд эрчүүд дунджаас доогуур хүүтэй зээл авчээ.
- Төслөөс хөнгөлөлттэй зээл олгосон 75 тэрбум төгрөгөөс эмэгтэй ЖДҮ эрхлэгч 33%, эрэгтэй ЖДҮ эрхлэгч 66%-ийг нь тус тус авчээ.

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨТӨЛБӨРИЙН KEYC

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨЛӨВЛӨЛТ

ЗОРИЛГО: Монгол Улсын зорилтот гурван аймаг (Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай) дахь хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай ЖДҮ эрхлэгчдэд **жендэрийн хувьд эн тэнцүү** зээл авах боломжийг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх

ЗОРИЛТ:

- **ЖДҮ эрхлэгч эмэгтэй, эрэгтэй хүмүүс** зээлийн шалгуурыг хангах чадавхыг бэхжүүлэх
- Арилжааны банкны **эмэгтэй, эрэгтэй эзэнтэй ЖДҮ-д** зээл олгох үйл явцыг хөнгөвчлөх

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Зорилтот аймаг, орон нутаг дахь **ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн** зээл авах хэрэгцээг тодорхойлох
- Зээлжих чадварыг сайжруулснаар зээл авах үйл явцыг нь хөнгөвчлөх
- Зан байдлыг нь өөрчлөх, санхүүгийн боловсрол олгох замаар **эмэгтэй, эрэгтэй эзэнтэй ЖДҮ-ийн** санхүүгийн оролцоог хангах

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО

Бүлгийн хэлэлцүүлэг:

- Уг бодлого хөтөлбөрийг жендэрийн эрх тэгш байдлыг хангахуйц байдлаар боловсруулсан уу?

Эмэгтэй, эрэгтэйх хүмүүс, охид, хөвгүүд үр шимийг нь эн тэнцүү хүртэх үү?

- Ямар сөрөг нөлөө гарч болзошгүй вэ? Тэдгээрээс хэрхэн зайлсхийх вэ?
- Уг бодлого, хөтөлбөр ямар үр нөлөө гаргахыг зорьж байгаа вэ?
- Үндсэн зарчим нь тэдгээр үр нөлөөнд хувь нэмэр оруулах үү?
- Богино хугацаа, дунд хугацаа, урт хугацааны үр нөлөө нь юу байгаасай гэж хүсч байна вэ?

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО

Төгсгөлийн хэлэлцүүлэг...

- Танай удирдлага уг бодлого, хөтөлбөр санаачилгыг бусад аймаг, сум, компанид түгээн хэрэгжүүлэхийг хүссэн.
- ХШҮ хийх явцад танай багийнхан нь жендэрийн тэгш бус байдал байгааг анзаарсан. Энэ нь эмэгтэйчүүд төсөл, бодлогын үр өгөөжийг их хүртээгүйг өгүүлж байв.
- Уг бодлого хөтөлбөрийг түгээн хэрэгжүүлэхдээ ийм тэгш бус байдал дахин үүсгэхээс зайлсхийхийн тулд цаашид авах дараагийн алхам нь юу байж болох вэ?



Монгол Улс: Институцийн өөрчлөлт
хийх замаар эрдэс баялгийн
менежментийг сайжруулах нь

Хаяг: Нэйшнл таймс ньус тауэр, 3-р давхар
Худалдааны гудамж, Хороо 1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160

Утас: 7610-5000